



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа болон Байгаль орчны
Удирдлагын тогтолцооны журмууд

(10-р хэсэг. Үйл ажиллагааны хяналт) ГАЗАР ХӨНДӨЛТИЙН ХЯНАЛТ,
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0005-M	Хувилбар: 1.1

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	4
Баримт бичгийн дугаар	4
Зорилго	4
Компанийн үүрэг амлалт	4
Эрх мэдэл ба удирдлага	5
2. ХАМРАХ ХҮРЭЭ	6
Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ	6
Бусад удирдлагын төлөвлөгөөнүүдтэй давхцах нь	6
3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	7
Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага	7
Гол уялдаа холбоо	8
4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТУУД	9
Монгол Улсын холбогдох хуулиуд.....	9
Монгол Улсын холбогдох стандартууд	9
БОНБНҮ-ний шаардлагууд	10
МУ-ын Засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, ЗГ-аас тавьж буй шаардлагууд.....	10
Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд	10
Рио Тинто группийн холбогдох стандарт.....	12
5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ	12
6. ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ	18
Удирдлагын төлөвлөгөөний хяналт, шинэчлэлт	18
7. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	18
Хяналт шинжилгээний шаардлагуудын тойм	18
Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	19
Хяналт шинжилгээний гол үйл ажиллагаа	20
8. СУРГАЛТ	21
Тойм	21
Танилцуулах сургалт	21
Ажлын байрны сургалт.....	21
9. ХЯНАЛТ БА ТАЙЛАГНАЛТ	21



ОЮУ ТОЛГОЙ ХХК

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E14-PLN-0005-M	Хувилбар: 1.1

Дотоод хяналт	21
Гадаад/Хөндлөнгийн хяналт	22
Баримт хадгалалт	22
10. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ	23
11. БАРИМТ БИЧГИЙГ БАТАЛСАН	24
12. ХАВСРАЛТ А: ГАЗАР ХӨНДӨЛТИЙН ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮҮРЭГ АМЛАЛТЫН БҮРТГЭЛ	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үүрэг, хариуцлага	7
Хүснэгт 2: Удирдлагын гол хяналт	13
Хүснэгт 3. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	19
Хүснэгт 4. Хяналт шинжилгээний гол арга хэмжээ	20

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: OT-10-E14-PLN-0005-M	Хувилбар: 1.1

1. ТАНИЛЦУУЛГА

Баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичиг нь Оюу Толгой (ОТ) компанид зориулагдсан Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө (“Удирдлагын Төлөвлөгөө”) юм. Уг удирдлагын төлөвлөгөөний баримт бичгийн дугаар нь: OT-10-E14-PLN-0005.

Зорилго

- Энэхүү Удирдлагын Төлөвлөгөөний зорилго нь: Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын гол уялдаа холбоог тогтоох,
- Үүрэг хариуцлагыг тодорхойлох,
- Хууль эрх зүйн шаардлагууд, стандартуудыг тодорхойлох,
- Компанийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журам, удирдамжуудыг тодорхойлох,
- Мониторинг хийх, тайлагнах журам, тэр дундаа гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох,
- Сургалтын шаардлагуудыг тодорхойлох,
- Нэмэлт материал, мэдээллийг эх сурвалжийг тодорхойлоход тус тус оршино.

Компанийн үүрэг амлалт

ОТ компанийн зорилго нь Өмнийн говийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэх юм. ОТ нь уурхайг хаах үед энэхүү зорилгодоо хүрэхээр зорьж байгаа хэдий ч (Рио Тинто группийн стратегид нийцүүлэн) ОТ-н уурхайн үйл ажиллагааны хугацаанд аль болох эрт эерэг нөлөө үзүүлэх боломжийг эрэлхийлэх болно. Тиймээс Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөөний зорилт нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн процесс болон журмуудыг бий болгоход оршино. Үүнд:

- Газар хөндөх үйл ажиллагааг хууль ёсны дагуу зөвшөөрсөн талбайд хамгийн бага хэмжээнд хязгаарлан, байгаль орчин, нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьжиргаанд нөлөөлөл үзүүлэхээс аль болох зайлсхийх, эсвэл нөлөөллийг бууруулах байдлаар аливаа барилга байгууламжуудын байршил, зураг төслийг төлөвлөж, барьж байгуулах.
- Хамгаалах шаардлагатай биологийн олон янз байдал, соёлын өвд учруулж болзошгүй эрсдэлийг эрт илрүүлэх зорилгоор газар хөндөлтийг эрт төлөвлөж, шаардлагатай бол зайлсхийх арга хэмжээг авна.
- Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахдаа зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах болон хамгааллын нэмэлт арга хэмжээ гэсэн шатлалыг баримтлан ажиллана.
- Эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд хангалттай хэмжээний, шаардлага хангасан шимт болон шимэрхэг хөрс, материалыг (ургалтын орчныг) цуглуулж, хадгална.
- Их хэмжээний нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн хаалтын үе шатанд болгон хойшлуулахаас илүүтэй хайгуул, барилга, малталт, олборлолтын ажлын явцад эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ.

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0005-М	Хувилбар: 1.1

- Нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор явцын нөхөн сэргээлтийг шуурхай, тасралтгүй явуулах бүхий л бэлтгэл ажлыг хангаж, гүйцэтгэнэ.
- Үйл ажиллагаа явуулж дууссаны дараах газар ашиглалт нь ашиг тустай байхаар нөхөн сэргээх ба нүүдэлчин малчид амьдрах, тэдний мал сүрэг бэлчихэд болон зэрлэг амьтдын амьдрах орчин болгон ашиглахаар төлөвлөж буй газрын нөхөн сэргээлтийг тогтоосон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн олон төрөл, зүйлээс бүрдсэн ургамлын бүлгэмдэл цаашид биеэ даан ургах чадвартай байхаар төлөвлөх ёстой.
- Нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай зүйлүүд, тэдгээрийн амьдрах орчинд үзүүлэх газар хөндөлтийн нөлөөллүүд (эерэг, сөрөг), тэдгээрт хийгдсэн нөхөн сэргээлт болон хамгааллын ажлуудыг бүртгэж баримтжуулснаар ховор зүйлийн бодгаль болон тэдгээрийн амьдрах орчинд уурхайн үйл ажиллагааны зүгээс эерэг нөлөөлөл үзүүлж байгааг нотлох баримтууд болох юм.

Хэрэглээ

Энэхүү Удирдлагын төлөвлөгөө нь:

- ОТ ХХК-ийн гэрээ, зөвшөөрлийн үндсэн дээр хууль ёсны дагуу ашигладаг, холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж буй бүх газрыг тогтвортой хамгаалах,
- Олон улсын санхүүгийн корпорацийн Гүйцэтгэлийн стандарт, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Гүйцэтгэлийн шаардлагын дагуу ОТ компанийн биологийн олон янз байдлын үүрэг амлалтуудыг (тодорхойлон тогтоосон нэн чухал амьдрах орчинтой холбоотой тодорхой шаардлагууд г.м) хэрэгжүүлэхтэй холбоотой журмуудын лавлах материал болоход оршино.

Тус удирдлагын төлөвлөгөөг 2014 оны 6 дугаар сард Рио Тинто группээс баталан гаргасан “Е14 Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн стандарт” болон 2017 оны 11 дүгээр сард шинэчлэгдэн батлагдсан “Е14 Газрын менежмент удирдлага, нөхөн сэргээлтийн стандарт”, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

Удирдлагын төлөвлөгөөний Хавсралт А 1 нь газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлттэй холбоотой БОННУ-ний үүрэг амлалтын хэрэгжилтийг хянах бүртгэл юм. Үүнд зааснаар БОННУ-нд заасаний ихэнх үүрэг амлалт нь тодорхой журмуудад тусгалаа олсон. Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь ОТ ХХК-ийн холбогдох журамтай тусгайлан нягт холбогддог. Тэдгээрт газар хөндөхтэй холбоотой эрсдэлийг урьдчилан сэргийлэх, бууруулах, нөхөн сэргээлтийг үр ашигтай удирдан зохицуулах үүргийг хэрэгжүүлэхийг шаарддаг.

Эрх мэдэл ба удирдлага Оюу толгой ХХК-ийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал (ЭМААБОАБ) хариуцсан Ерөнхий менежер энэхүү удирдлагын төлөвлөгөөг хариуцна. Үйл ажиллагаанд орсон өөрчлөлтийг тусгах зорилгоор энэхүү удирдлагын төлөвлөгөөнд хоёр жил тутамд өөрчлөлт оруулна. Тус удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай аливаа хүсэлтийг дээрх албан

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0005-М	Хувилбар: 1.1

тушаалтанд гаргах ба өөрчлөлтийн удирдлагын журамд заасанчлан зохих байдлаар хянаж, батлах үйл явцыг дамжих нөхцөл тавигдана.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Оюу Толгой ХХК-ийн хууль ёсны гэрээ, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг, ашигладаг бүх газар эсхүл хайгуулын шатнаас уурхайн хаалт хүртэлх төслийг хэрэгжүүлэх бүхий л үе шатанд үйл ажиллагааны хувьд хариуцлага хүлээх бүх газарт энэхүү удирдлагын төлөвлөгөө хамаарна. Энэхүү төлөвлөгөөнд бидний үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар өртөж байгаа болон биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалахаар авсан газар багтана.

Бусад удирдлагын төлөвлөгөөнүүдтэй уялдах нь

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд (БОНУТ) (ОТ-10-PLN-0003) тодорхойлсон Оюу толгой компанийн Ашиглалтын шатны удирдлагын цогц төлөвлөгөөний нэг хэсэг юм. Тус удирдлагын төлөвлөгөө нь өөр бусад олон удирдлагын төлөвлөгөөтэй зарим талаараа давхацсан, харилцан холбоотой. Тухайлбал:

- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е16-PLN-003), ялангуяа зэрлэг ан амьтдын амьдрах орчин, ховор ургамлын төрөл зүйл, нутгийн ургамлын аймгийг хамгаалахтай холбоотой;
- Бэлчээрийн менежмент, малчдын амьжиргааг дэмжих удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0013), бэлчээрийн удирдлагатай холбоотой;
- Экосистемийн үйлчлэлийн хяналт шинжилгээний төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0009), ОТн үйл ажиллагааны үр нөлөө, нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг үнэлэх боломжийг олгодог олон тооны үзүүлэлтийг нарийвчлан харуулсан.
- Дүйцүүлэн хамгаалах удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е16-PLN-0003), ялангуяа биологийн олон янз байдалд үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, компанийн эерэг нөлөө үзүүлэх амлалтад хүрэхтэй холбоотой;
- Эрдсийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е13-PLN-0001);
- Эрдсийн хаягдал, Хүчиллэг чулуулгийн урсац, хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е8-PLN-0002);
- Гүйцэтгэгчийн удирдлагын бүтэц (ОТ-07-PLN-9001);
- Уурхайн хаалтын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0002);
- Олон талт хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө (ОТ-05-PLN-0001).
- Бусад.

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0005-М	Хувилбар: 1.1

3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх албан тушаалтнуудын үүрэг, хариуцлага

Уг төлөвлөгөөний хэрэгжилтэнд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлагыг дор харуулав.

Хүснэгт 1. Үүрэг, хариуцлага

Албан тушаал	Үүрэг, хариуцлага
ОТ ХХК-ийн ЭМААБОАБ-ын хэлтсийн Ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> Хэрэгжилтийг хангах үүднээс шаардлагатай нөөц болоцоогоор хангах зэргээр тус удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцах. Газар ашиглах шаардлагатай холбоотой зорилтуудын талаар холбогдох хэлтсийн менежерүүдтэй тогтмол харилцаатай байх.
Байгаль орчин, биологийн олон янз байдал хариуцсан менежер	<ul style="list-style-type: none"> Энэхүү төлөвлөгөөг ОТ ХХК-ийн бүх ажилтан, гүйцэтгэгчдэд хүргэх. Үйл ажиллагааны бүх хэлтсийн менежерүүд энэхүү удирдлагын төлөвлөгөөнд заасан холбогдох хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх байдлыг хангах. ОТ-н ажилтнууд тус удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, сайжруулах талаар хангалттай мэдлэгтэй байх, энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн зөвлөгөө авах зорилгоор мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажиллах байдлыг хангах. Газар хөндөх, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх, хуваарилахдаа бусад хэлтэстэй хамтарч ажиллах.
Хэлтсийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> Энэхүү төлөвлөгөөнд тусгасан удирдлагын хяналтын арга хэмжээг ажлын байр/үйл ажиллагааны талбайд хэрэгжүүлэх. Энэхүү удирдлагын төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчны багт төлөвлөсөн газар хөндөх үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээлэл, улирлын шинэ мэдээг өгөх.
ЭМААБО-ны Эрх зүйн хэрэгжилтийн баг	<ul style="list-style-type: none"> МУ-ын Газрын тухай хууль тогтоомжид орсон өөрчлөлт, улсын болон төслийн стандартуудад оруулсан өөрчлөлт/шинэчлэлийг тус удирдлагын төлөвлөгөөнд нэгтгэн оруулах зорилгоор Байгаль орчны менежер, газар, нөхөн сэргээлтийн багт шуурхай мэдээлэх.
Байгаль орчны хэлтсийн Газар, нөхөн сэргээлт хариуцсан баг	<ul style="list-style-type: none"> Холбогдох журмуудыг боловсруулж, шинэчлэн сайжруулж байх Холбогдох журмуудыг мөрдүүлэх, бүртгэл мэдээллийг байнга хөтлөж, шинэчилж байх. Энэхүү удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн жилийн тайланг бэлтгэх ОТ ХХК-ийн газар ашиглалт, нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг тогтмол, үнэн зөв, хамгийн сүүлийн үеийн байдлаар шинэчилж ГМС дээр бүртгэж байх

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0005-М	Хувилбар: 1.1

Албан тушаал	Үүрэг, хариуцлага
Орон нутгийн харилцааны хэлтэс	<ul style="list-style-type: none"> Газартай холбоотой орон нутгийн иргэдийн санал гомдол, илрүүлсэн/бүртгэсэн осол зөрчлийг Байгаль орчны хэлтэс, нөхөн сэргээлтийн багт шуурхай мэдээлж, асуудалд яаралтай арга хэмжээ авах, тус удирдлагын төлөвлөгөөний гүйцэтгэлийн гол үзүүлэлтийг үнэн зөв бүртгэх байдлыг хангана.
Засгийн газартай харилцах хэлтсийн зөвлөх	<ul style="list-style-type: none"> ОТ ХХК-ийн ашиглаж буй нийт газрын мэдээллийн санг тогтмол, үнэн зөв шинэчлэх үүднээс Байгаль орчны газарзүйн мэдээллийн системийн ажилтанд шаардлагатай баримт бичиг (Компанийн хариуцах газартай холбогдох зөвшөөрөл, баталгаа, гэрчилгээ), бусад холбогдох мэдээлэл өгөх.
Ахлах маркшейдер, Уурхайн техникийн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> ОТ үйл ажиллагааны улмаас, тэр дундаа Хаягдал хадгалах байгууламжийн улмаас эвдэрсэн газрын шинэчилсэн мэдээллийг сар бүр өгч байх.
ОТ ХХК-ийн бүх ажилтан, гэрээ байгуулан ажиллаж буй аливаа этгээд	<ul style="list-style-type: none"> Тус удирдлагын төлөвлөгөөнд тусгасан байгаль орчны шаардлагуудыг дагаж мөрдөх.

Гол уялдаа холбоо

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн гол интерфэйсүүд (ө.х. уг удирдлагын төлөвлөгөөний элементүүдийг ханган нийлүүлэх хариуцлага бүхий үүргүүд) нь:

- ЭМААБОАБ-ийн хэлтэс;
- Орон нутгийн харилцааны хэлтэс;
- Баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн хэлтэс;
- Инженерин/Засвар үйлчилгээ;
- Ил уурхай, Хаягдал хадгалах байгууламжийн хэлтэс;
- Гүний уурхайн хэлтэс
- Зөвшөөрөл хариуцсан баг
- Хуулийн хэлтэс.

Гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнтэй холбоотой хүлээлтийг орон нутгийн удирдлагатай удирдан зохицуулах шаардлагын улмаас энэхүү удирдлагын төлөвлөгөөний гадны гол харилцаа холбоогоор доорх оролцогч талуудыг тодорхойлов:

- Орон нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагууд;
- Орон нутгийн иргэд;
- Гурван талт зөвлөл, малчдын Хамтарсан ажлын хэсэг зэрэг сонирхлын бүлгүүд.

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0005-М	Хувилбар: 1.1

4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТУУД

ОТ ХХК нь олон төрлийн хууль эрх зүйн болон бусад шаардлагуудыг (жишээ нь, ОТ ХХК ба Рио Тинто группийн стандарт, олон улсын санхүүгийн байгууллагын стандарт гэх мэт) мөрдлөгө болгон ажилладаг. Газар, нөхөн сэргээлттэй тай холбоотой стандарт, хууль эрх зүйн шаардлагын талаарх товч мэдээллийг дараахь байдлаар гаргасан.

Уурхай нь бүхий л үйл ажиллагааныхаа явцад холбогдох хууль, дүрэм журам, стандартуудыг дагаж мөрдөх ёстой (“Үйл ажиллагааны стандартууд”). Үйл ажиллагааны стандарт нь дараахь хэсгүүдээс бүрдэнэ:

- Монгол Улсын холбогдох хуулиуд;
- Монгол Улсын холбогдох стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлага;
- Монгол Улсын төрийн байгууллагын өмнө хүлээсэн үүрэг амлалт, тэдгээрээс тавьсан шаардлага;
- Зээлдүүлэгчийн холбогдох стандартууд;
- Рио Тинто группийн холбогдох стандартууд;
- Оюу Толгой компани мөрдөх үүрэг хүлээсэн салбарын бусад эрх зүйн баримт бичгүүд.

Монгол Улсын холбогдох хуулиуд

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995;
- Газрын тухай хууль, 2002;
- Газрын төлбөрийн тухай хууль, 1997;
- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012;
- Газрын хэвлийн тухай хууль, 1988;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль, 2014;
- Амьтны тухай хууль, 2012.
- Байгалийн ургамлын тухай хууль, 1995;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012;
- Ашигт малтмалын тухай хууль 2006.

Монгол Улсын холбогдох стандартууд

Стандартчилал, хэмжилзүйн газар үндэсний стандартыг боловсруулдаг. Эдгээр стандартад ургамалжуулалт зэрэг газрын нөхөн сэргээлт, уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой биологийн олон янз байдлын асуудлыг тусгасан Үүнд:

- MNS 5914:2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 5915:2008. Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0005-М	Хувилбар: 1.1

- MNS 5917:2008. Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5918:2008. Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

БОНБНҮ-ний шаардлагууд

БОНБНҮ-ний Байгаль хамгаалах төлөвлөгөө болон Орчны мониторингийн хөтөлбөрүүдэд тусгагдсан газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын шаардлагууд нь энэхүү Удирдлагын төлөвлөгөөнд багтсан болно. Газар хөндөх, нөхөн сэргээлттэй холбоотой ОТ ХХК-ийн хуулиар хүлээсэн үүрэг амлалтыг МУ-ын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу бэлтгэсэн.

МУ-ын Засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, ЗГ-аас тавьж буй шаардлагууд

ОТ Хөрөнгө оруулалтын гэрээний 6.4, 6.9, 6.10 болон 6.11-р заалтууд:

- 6.4. Хөрөнгө оруулагч нь Оюу толгой төслийн хэрэгжилттэй холбоотой Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /цаашид “БОХТ” гэх/, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах жил бүрийн бүх зардлыг хариуцах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд дурдсан арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаа тухай хараат бус, мэргэшсэн, эрх бүхий хөндлөнгийн шинжээчийн тайланг 3 /гурав/ жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 6.9. Хөрөнгө оруулагч нь Үндсэн үйл ажиллагаатайгаа холбоотой байгаль орчны шинжилгээ, мониторингийн иж бүрэн үнэлгээний хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 6.10. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа материаллаг сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол Хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.
- 6.11. Оюу толгой төслийн үйл ажиллагаанаас шууд шалтгаалан урьдчилан тооцоолоогүй болон нөхөж болшгүй байгаль, экологийн сөрөг нөлөөлөл, хохирол учирвал уг хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлсон хэмжээ, экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн Хөрөнгө оруулагч нөхөн төлнө.

Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК) болон Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-аас боловсруулсан олон улсын стандартуудыг Оюу Толгой ХХК мөрдөнө. ОТ ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 6-ийн шаардлага, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага ПР6-г биелүүлэх үүрэг хүлээсэн. Энэ нь байгалийн амьдрах орчинд цэвэр/нэгж алдагдал/хохирол үүсгэхгүй, холбогдох биологийн олон янз байдлыг сайжруулахыг шаарддаг. Уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор мөрдөх гол удирдамж нь ОУСК-ийн уурхайн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (БОЭМАА) удирдамж (2007) байна.

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0005-М	Хувилбар: 1.1

ОУСК-ийн уурхайн БОЭМАА-ны удирдамж

Газар хөндөх, шимт болон шимэрхэг хөрсний удирдлага, нөхөн сэргээлттэй холбоотойгоор мөрдөх гол удирдамж нь ОУСК-ийн уурхайн Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны (БОЭМАА) удирдамжид¹:

Амьдрах орчинд түр болон байнгын оруулах өөрчлөлтийг боломжит хэмжээгээр бууруулж, нэн чухал амьдрах орчныг хамгаалах, хадгалах шаардлагад нийцсэн байх ёстой. Санал болгох удирдлагын стратегид доорх багтана:

- *Эх газрын чухал амьдрах орчинд үзүүлэх нөлөөллөөс сэргийлсэн байршилд уурхайн цогцолборт нэвтрэх зам, байгууламжийг байрлуулах, хайгуул, барилгын ажлыг жилийн эмзэгшил өндөртэй улирлаас зайлсхийн төлөвлөх;*
- *Хөрс, ургамлын хөндөлтийг багасгах/бууруулах;*
- *Ашиглалтын дараах нөхөн сэргээлт (суурь судалгаа, үнэлгээ, зүйлийг бүрэн аврах ажил багтана), хохирлыг дүйцүүлэн хамгаалах, шууд хэрэглэгчийн нөхөн төлбөр зэрэг амьдрах орчны төрөл, болзошгүй нөлөөлөлд тохиромжтой бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;*
- *Нөлөөлөлд эмзэг газруудыг төлөвлөх, зайлсхийх, нөлөөллийн бүсийг бий болгож хянах;*
- *Шимт хөрсийг хамгаалах арга хэмжээнд (жнь: талбайн нөхөн сэргээлтэд зориулж шимт болон хөрс хуулалтын материалыг тусгаарлах, хадгалах), овоолгын байршил, хэлбэр, хадгалах хугацаа, ургамалжуулах/хучилт, дахин ашиглалт, олон дахин зөөхгүй байхаар төлөвлөх зэрэг гол хүчин зүйлс багтана;*
- *Үржил шимт хөрсийг урьдчилан хуулсан бол ирээдүйд газрыг нөхөн сэргээхэд ашиглахаар хадгалах ёстой. Үржил шимт хөрсний удирдлага ирээдүйд хэрэглэхэд бэлэн байлгахад зориулж хөрсний чанарыг хадгалсан байна. Хөрсний овоолгыг богино хугацаанд хамгаалах арга хэмжээ авах эсвэл элэгдэхээс сэргийлж ургамалжуулсан байх хэрэгтэй;*
- *Нөхөн сэргээлт, хаалтын үйл ажиллагааны үед хэрэглэх хөрс материал (ургалтын орчин) чанар бүтцийг хамгаалах (жнь: хучих).*
- *Ургалтын орчин (хөрс материал) нь тухайн газрын цаашдын ашиглалтад тохирсон, тухайн орон нутгийн уур амьсгалд зохицсон унаган ургамалын ургалтыг хангалттай дэмжиж чадах эсэхийг нягталбал зохино. Ургалтын орчны зузаан нь орчны эвдрээгүй хөрс болон газрын цаашдын ашиглалтын зорилгод тохирч байх ёстой.*
- *Уурхайн барилга байгууламж болон дэд бүтцийг нураах, ил уурхайг хаах, гүний уурхайн ажлын хэсэг болон босоо амнуудад гадны хүн нэвтрэхээс сэргийлэх, тэдгээрийг аюулгүй болгож тогтворжуулах арга хэмжээнүүдийг авах, уурхайн налууг нөхөн сэргээх, уурхайгаас гарч буй ус болон хаягдлын овоолгууд нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд эрсдэл учруулахгүй байх нөхцлийг хангах зэргээр уурхайн олборлолт явуулсан газрыг тасралтгүй байдлаар нөхөн сэргээх үүрэг амлалт бүхий Уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулна гэж заасан байдаг.*

¹ Хуудас 10

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0005-М	Хувилбар: 1.1

Рио Тинто группийн холбогдох стандарт

Газар хөндөлт, нөхөн сэргээлттэй холбоотой Рио Тинто группийн үндсэн стандарт нь *Е14 – Газрын удирдлага, нөхөн сэргээлтийн стандарт, 2017 мөн Уурхайн хаалтын төлөвлөгөө, 2013 юм.*

5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ

Үйл ажиллагааны удирдлагын гол хяналт нь БОННУ (Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ)-ний үүрэг амлалтыг багтаасан холбогдох журмуудад чиглэсэн бөгөөд доорх Хүснэгт 2-т үзүүлэв. Мөн түүнчлэн (1) журамд тусгаагүй; (2) газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлттэй тусгайлан холбогдоогүй; (3) бусад удирдлагын төлөвлөгөөнд тусгаагүй БОННУ-ний үүрэг амлалтыг Хүснэгт 2-т оруулсан.

Энэ Удирдлагын төлөвлөгөө нь ОТ ХХК-ийн ажилтан, гэрээт гүйцэтгэгчдийн явуулдаг өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан мэдээлэл бүхий доорх баримт бичгүүдэд тусгагдсан. Үүнд:

- Газар хөндөх зөвшөөрлийн журам (ОТ-10-Е14-PRC-0003);
- Нэн тэргүүнд хамгаалах ач холбогдолтой ургамлыг хамгаалах журам (ОТ-10-Е14-PRC-0007)
- Шимт хөрстэй ажиллах журам (ОТ-10-Е14-PRC-0001);
- Урт хугацааны Шимт хөрсний овоолгын чанарыг хянах журам (ОТ-08-TMP-0001)
- Нөхөн сэргээлтийн журам (ОТ-10-Е14-PRC-0010)
- Хөрсний бохирдуулагч бодисуудын дээж авах стандарт ажлын журам (ОТ0243-00-SWPO-0002)
- Хөрсний эрүүл ахуйн болон бактериологийн хяналт шинжилгээ явуулах стандарт ажлын журам (ОТ0243-00-SWPO-0003)
- Хээрийн нөхцөлд хөрсний шинж чанарыг тодорхойлох стандарт ажлын журам (ОТ0243-00-SWPO-0004)
- Хөрсний хими, физикийн шинж чанарын дээж авах стандарт ажлын журам (ОТ0243-00-SWPO-0005)
- Осол, зөрчлийн удирдлагын журам (ОТ-14-PRC-0001)

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-PLN-0005-М	Хувилбар: 1.1

Хүснэгт 2: Удирдлагын гол хяналт

Дугаар	Сэдэв/аспект	Хамаарал/нөлөөлөл	Хяналтын арга хэмжээний тодорхойлолт	Хариуцах талууд	Баталгаажуулалтын арга
LR01	Газар хөндөлт	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн нөлөөлөлд өртсөн (бэлчээргүй болох /бэлчээр, ус ашиглах боломжгүй болох) 	<ul style="list-style-type: none"> ОТ ХХК нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараах газар нь ашиг тустай байхаар газрыг нөхөн сэргээх ба нүүдэлчин малчид амьдрах, тэдний мал сүрэг бэлчихэд болон зэрлэг амьтдын амьдрах орчин болгон ашиглахаар төлөвлөж буй газрын нөхөн сэргээлтийг тогтоосон шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэн олон төрөл, зүйлээс бүрдсэн ургамлын бүлгэмдэл цаашид биеэ даан ургах чадвартай байхаар төлөвлөх ёстой. 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж; Орон нутгийн харилцааны хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Нөхөн сэргээлтийн баримт
LR02	Газар хөндөлт	<ul style="list-style-type: none"> Хяналтгүй, шаардлагагүй газар хөндөлт 	<ul style="list-style-type: none"> Газар хөндөхтэй холбоотой шаардлагуудыг тусгаж, дотоодын зөвшөөрөл авах үйл ажиллагааны шаардлагыг тогтоосон Газар хөндөх зөвшөөрөл авах журмыг хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж Үйл ажиллагаа, дэд бүтцийн хэлтэс Гэрээт компани/гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> Газар хөндөх зөвшөөрлийн бүртгэл, осол зөрчлийн бүртгэл
LR03	Шимт болон шимэрхэг хөрс	<ul style="list-style-type: none"> Шимт хөрс алдагдах Шимт хөрсний овоолгын чанарт тоос нөлөөлөл 	<ul style="list-style-type: none"> Шимт болон шимэрхэг хөрс хуулалтыг төлөвлөх, хуулах, хадгалах, ашиглахтай холбоотой (үүгээр хязгаарлагдахгүй) мэдээллийг агуулсан Шимт болон шимэрхэг хөрсийг хадгалах журмыг хэрэгжүүлэх. 	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаа, дэд бүтцийн хэлтэс ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж 	<ul style="list-style-type: none"> Шимт болон шимэрхэг хөрсийг хуулж, хадгалах ажлын гүйцэтгэлийн хяналтын тайлан Тухайн тодорхойлсон шаардлагыг тусгасан Газар хөндөх зөвшөөрөл Шимт болон шимэрхэг хөрсний овоолгын

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: OT-10-E14-PLN-0005-M	Хувилбар: 1.1

			<ul style="list-style-type: none"> Уурхайн цогцолборын нийт хэрэгцээ, тэнцвэрт байдлыг хангах үүднээс нөхөн сэргээлтэд шаардлагатай шимт болон шимэрхэг хөрс, хүчиллэг урсац үүсгэхгүй хаягдал чулуулаг зэрэг геологийн бусад материалыг ялгаж, овоолно. Шимт болон шимэрхэг хөрсний овоолгын чанарыг үр дүнтэй хянах ажлын цар хүрээ, шаардлагыг тодорхойлсон урт хугацааны Шимт болон шимэрхэг хөрсний овоолгын чанарын хяналтын журмыг хэрэгжүүлэх. 		хяналтын шинжилгээний тайлан
LR04	Хөрс	<ul style="list-style-type: none"> Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай, дэд бүтцийн талбайн хөрсний чанарт үзүүлэх нөлөөлөл 	<ul style="list-style-type: none"> Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай, дэд бүтцийн талбайн хөрсний чанарт үзүүлэх болзошгүй нөлөөллийг боломжтой газар нь бууруулах арга хэмжээг агаарт хаягдах хийн хаягдал, хөрсний бохирдлыг хянах арга хэмжээний хамтаар хэрэгжүүлэх. Холбогдох АСЖ-ын дагуу хөрсний хяналтыг (хими, физикийн шинж чанар, бохирдол г.м) тогтмол хэрэгжүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> Хөрсний бохирдуулагч бодисоос дээж авах (OT0243-00-SWPO-0002) Хөрсний эрүүл ахуйн болон бактериологийн шинжилгээ явуулах 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж 	<ul style="list-style-type: none"> Лабораторийн хариу Байгаль орчны жилийн тайлан

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: OT-10-E14-PLN-0005-M	Хувилбар: 1.1

			<p>(OT0243-00-SWPO-0003)</p> <ul style="list-style-type: none"> - Хээрийн нөхцөлд хөрсний шинж чанарыг тодорхойлох (OT0243-00-SWPO-0004) - Хөрсний хими, физикийн шинж чанарын дээж авах (OT0243-00-SWPO-0005) • Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай, дэд бүтцийн талбайн газрын чанарын үнэлгээний ажлыг (газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа) таван жил тутам МУ-ын Газрын тухай хуулийн дагуу зохион байгуулна; 	<ul style="list-style-type: none"> • Засгийн газартай харилцах хэлтэс 	<ul style="list-style-type: none"> • Газрын чанарын үнэлгээний тайлан
LR05	Нөхөн сэргээлт	<ul style="list-style-type: none"> • Газар хөндөлт 	<ul style="list-style-type: none"> • Уурхайн ашиглалтаас өмнөх байгалийн төрх байдлыг алдагдуулахгүй, нэн чухал амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлэх OT ХХК-ийн биологийн олон янз байдлын үүрэг амлалтад нийцэх гүйцэтгэлийн шалгуурт үндэслэн, газар ашиглалтын эцсийн зорилт буюу газрыг олборлолтын өмнөх нөхцөлд хүргэх, түүнчлэн дүйцэх ургамлын төрөл, ургамлан бүрхэвч, усны эх сурвалж, зэрлэг амьтдын амьдрах орчин, малын бэлчээрийг нөхөн сэргээх үүднээс Нөхөн сэргээлтийн журам болон Байгаль орчныг хамгаалах менежментийн жил 	<ul style="list-style-type: none"> • ЭМААБОАБ хэлтсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж 	<ul style="list-style-type: none"> • Нөхөн сэргээлтийн бүртгэл

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: OT-10-E14-PLN-0005-M	Хувилбар: 1.1

			бүрийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.		
LR06	Нөхөн сэргээлт	<ul style="list-style-type: none"> Газар ухах, дүүргэх, тэгшлэх, шороог нь ашиглах зорилгоор ухаж ашигласан газар, хаягдлын овоолго үүсгэх зэргээс топограф болон орчны газрын байдалд үзүүлэх өөрчлөлтүүд 	<ul style="list-style-type: none"> ОТ ХХК-ийн Нөхөн сэргээлтийн журмыг Рио тинто группийн Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн стандарт (E14)–ын дагуу хэрэгжүүлэх Компани эвдэрсэн газартай тэнцэх хэмжээний талбайг нөхөн сэргээнэ. 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж Үйл ажиллагаа, дэд бүтцийн хэлтэс Гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> Газар хөндөх зөвшөөрөл хаасан хяналт шалгалтын тайлан / Нөхөн сэргээлт хийсэн акт Нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээний бүртгэлүүд Байгаль орчны менежментийн жилийн эцсийн тайлан
LR07	Нөхөн сэргээлт	<ul style="list-style-type: none"> Ургамлан бүрхэвчийн алдагдал 	<ul style="list-style-type: none"> ОТХХК-ийн Биологийн нөхөн сэргээлтийн журмыг Рио тинто группийн Газрын менежмент, нөхөн сэргээлтийн стандарт (E14), ОТ ХХК-ийн Нэн тэргүүний хамгааллын ач холбогдолтой ургамлыг хамгаалах журмын дагуу хэрэгжүүлэх; Компани эвдэрсэн газартай тэнцэх хэмжээний талбайг нөхөн сэргээнэ. Компанийн зүгээс хөндөгдсөн талбай дахь хамгааллын ач холбогдолтой ургамлын зүйлийг анх байсан нөхцөлтэй дүйцэхүйц эсхүл түүнээс илүү сайн хэмжээнд нөхөн сэргээнэ. 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж Үйл ажиллагаа, дэд бүтцийн хэлтэс Гүйцэтгэгчид 	<ul style="list-style-type: none"> Нөхөн сэргээлтийн бүртгэл Хөндөгдөхөөс өмнөх үеийн ургамлын хяналт суурь судалгааны бүртгэл Нөхөн сэргээлтийн дараах хяналтын шинжилгээний бүртгэл, тайлан

Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр огноо:	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е14-ПЛН-0005-М	Хувилбар: 1.1

LR08	Нөхөн сэргээлт	<ul style="list-style-type: none"> Ургамлан бүлгэмдэл болон ,тодорхой ургамлын зүйл алдагдах/устгах 	<ul style="list-style-type: none"> Нөхөн сэргээлтийн журмыг хэрэгжүүлэх, Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ашиглах. Эвдрэхийн өмнөх нөхцөлтэй дүйцэх хэмжээний талбайг нөхөн сэргээнэ. 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж 	<ul style="list-style-type: none"> Нөхөн сэргээлтийн дараах хяналт шинжилгээний бүртгэл, тайлан
LR09	Топограф	<ul style="list-style-type: none"> Уурхайн тусгай зөвшөөрлийн талбайн доторх барилга байгууламжуу даас орчны харагдах байдалд үзүүлэх нөлөөлөл. 	<p>Оюу толгой ХХК богино хугацааны барилга байгууламжуудын нүдэнд үзэгдэхүйц нөлөөллүүдийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авна.</p> <ul style="list-style-type: none"> Жижиг байгууламжууд болон ил уурхайд хэлбэршүүлэлт ашиглах, Хаягдал Чулуулгийн Овоолгийн хэлбэршүүлэлтийн шалгалтыг хийх, Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай дахь хүн ам суурьшсан газрын 10%-д ногоон байгууламж байгуулах. Оюу толгой ХХК нь үйл ажиллагаа явуулахдаа шаардлагатай газар байгалийн топографийг судалж ашиглана. 	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБ хэлтэсийн Байгаль орчин, биологийн олон янз байдлын нэгж Ил уурхайн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Нөхөн сэргээлтийн бүртгэл
